ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/160/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас:260512 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Ц.Батсүх<br>Утас: 261885 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn<br><br>Аудитор: Б.Батхишиг<br>Утас: 261885 Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/788

танай ____________-ны №____________-т

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ДАВААЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 26,080.9 мянган төгрөгийн зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 8,999.4 мянган төгрөг зарцуулсан;
- Ахмадын санг зохих журмын дагуу байгуулаагүй боловч уг сангийн зориулалтыг үндэслэн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 13,900.0 мянган төгрөг зарцуулсан;
- Төсвийн захирагч нь хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын тайланг гаргаж ирүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн төсвийн тухай хуулийн 8.9.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон

зарласантай холбогдуулан зохион байгуулсан Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалд 12 улсын төлөөлөл, 169 мянган хүн зочилсон байна.

"Соёлын бүтээлч сар-2024" аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, Улсын драмын эрдмийн театр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Үндэсний урлагийн их театр, Хүүхэлдэйн театр, Хүүхэд залуучуудын театр, Улсын Филармони зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагууд оролцож, урлагийн тоглолт, үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллажээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 87,710.0 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс 3,951,562.2 мянган төгрөг, нийт 4,039,272.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 4,039,272.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй, аудитын цар хүрээнд удирдлагын хязгаарлалтын улмаас хангалттай ба зохистой нотолгоо олж авах боломжгүй ч энэхүү тайлангийн хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлыг толилуулж байна.

Соёлын төв өргөөний байрны өмчлөл, ашиглалтын талаар Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 61 дүгээр тэмдэглэлд Соёлын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **129,953,775.65** | **287,410,080.26** |
| **33** | **АВЛАГА** | - | 517,255.72 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 517,255.72 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 129,953,775.65 | 286,892,824.54 |
| **351** | **Түүхий эд материал** | 26,473,919.90 | 30,122,769.90 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 25,475,919.90 | 29,264,769.90 |
| 35130 | Эм боох материал | 998,000.00 | 858,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 31,073,325.00 | 63,038,497.58 |
| **354** | **Хангамжийн материал** | 72,406,530.75 | 193,731,557.06 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,378,090.00 | 45,407,790.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,829,930.75 | 36,191,207.06 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 932,500.00 | 485,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 2,112,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,266,010.00 | 109,535,560.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,654,093,952.87** | **2,868,522,965.27** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,654,093,952.87 | 2,868,522,965.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 806,092,672.55 | 1,021,338,351.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,027,777.83) | (2,694,444.51) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 868,829,351.53 | 1,081,451,206.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (365,621,696.78) | (496,840,448.07) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 396,069,154.36 | 559,628,195.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (119,371,358.73) | (146,092,157.79) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,645,000.00 | 6,645,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,430,000.00) | (5,759,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,848,001,280.32 | 1,847,184,613.72 |
| 39301 | Программ хангамж | 8,020,000.00 | 8,020,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,654,999.68) | (3,471,666.28) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,842,636,280.00 | 1,842,636,280.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,784,047,728.52** | **3,155,933,045.53** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,210,750.00** | **2,444,200.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,210,750.00 | 2,444,200.00 |
| **413** | **Өглөг** | 1,210,750.00 | 2,444,200.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,210,750.00 | 2,444,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 2,444,200.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,210,750.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,782,836,978.52** | **3,153,488,845.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,782,836,978.52 | 3,153,488,845.53 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,782,836,978.52 | 3,153,488,845.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,907,389,385.55 | 2,782,836,978.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 875,447,592.97 | 370,651,867.01 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,784,047,728.52** | **3,155,933,045.53** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,198,435,117.78** | **11,255,577,423.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,291,673,607.78** | **459,862,068.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,291,673,607.78 | 459,862,068.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,291,673,607.78 | 459,862,068.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 860,000.00 | 219,998.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 999,955,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан /Үндсэн хөрөнгө | 114,763,817.88 | 140,108150.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан о /Материал/ | 176,094,789.90 | 319,533.920.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,906,761,510.00** | **10,795,715,355.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,140,866,300.00 | 6,756,443,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,140,866,300.00 | 6,756,443,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 765,895,210.00 | 4,039,272,155.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 87,710,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 765,895,210.00 | 3,951,562,155.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,287,280,469.71** | **10,884,925,556.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,287,280,469.71** | **10,884,925,556.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,971,578,165.62 | 9,301,576,944.06 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,518,673,884.70 | 3,247,028,717.29 |
| 210101 | Үндсэн цалин | 1,671,533,360.81 | 1,977,922,081.93 |
| 210102 | Нэмэгдэл | 392,494,950.30 | 520,421,657.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 263,771,575.61 | 462,011,696.80 |
| 210104 | Урамшуулал | 190,873,997.98 | 286,673,280.69 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 315,940,276.85 | 406,779,472.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 216,333,293.12 | 278,063,419.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,464,745.74 | 32,771,488.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,112,195.19 | 18,518,172.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,865,004.20 | 15,283,872.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,165,038.60 | 62,142,518.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 158,151,375.44 | 174,419,851.98 |
| 210304 | Байрны түрээс | 158,151,375.44 | 174,419,851.98 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 104,854,011.28 | 161,099,123.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 30,814,990.00 | 52,624,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,959,868.73 | 41,088,255.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,397,552.55 | 51,393,477.69 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 15,992,990.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн/ТӨҮГ/ | 6,681,600.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 442,500.00 | 140,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 442,500.00 | 140,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,191,440.00 | 62,945,490.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 155,000.00 | 3,300,000.00 |
| 210602 | Тавилга | - | 3,450,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,036,440.00 | 56,195,490.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 8,980,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | - | 8,980,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 580,904,983.11 | 614,532,741.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 576,551,100.11 | 610,424,631.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 193,773.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 52,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 4,108,110.00 | 4,108,110.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,287,419,694.24 | 4,625,651,548.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,090,590,060.79 | 4,344,065,010.43 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,900,000.00 | 68,750,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 186,929,633.45 | 212,836,537.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,315,702,304.09 | 1,583,348,611.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,268,327,636.00 | 1,409,168,671.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 990,439,636.00 | 1,037,770,671.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 277,888,000.00 | 371,398,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 42,966,896.17 | 174,179,940.94 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,966,896.17 | 174,179,940.94 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,407,771.92 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,407,771.92 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **911,154,648.07** | **370,651,867.01** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 35,707,055.10 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 35,707,055.10 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (35,707,055.10) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **875,447,592.97** | **370,651,867.01** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **5,941,119,447.92** | **10,795,935,353.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **860,000.00** | **219,998.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 860,000.00 | 219,998.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 860,000.00 | 219,998.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 860,000.00 | 219,998.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,940,259,447.92** | **10,795,715,355.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,140,866,300.00 | 6,756,443,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,140,866,300.00 | 6,756,443,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 799,393,147.92 | 4,039,272,155.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 33,497,937.92 | 87,710,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 765,895,210.00 | 3,951,562,155.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,876,782,122.92** | **10,508,777,953.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,876,782,122.92** | **10,508,777,953.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,561,079,818.83** | **8,925,429,341.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,517,314,783.06 | 3,246,863,127.29 |
| 210101 | Үндсэн цалин | 1,676,644,416.69 | 1,977,756,491.93 |
| 210102 | Нэмэгдэл | 386,951,792.67 | 520,421,657.87 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 263,209,387.16 | 462,011,696.80 |
| 210104 | Урамшуулал | 190,509,186.54 | 286,673,280.69 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 316,088,628.49 | 408,218,867.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 216,525,644.76 | 279,299,775.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,437,245.74 | 32,805,328.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,107,795.19 | 18,518,172.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,863,904.20 | 15,283,872.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,154,038.60 | 62,311,718.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 158,151,375.44 | 174,419,851.98 |
| 210304 | Байрны түрээс | 158,151,375.44 | 174,419,851.98 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 84,459,746.73 | 80,774,488.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 34,499,980.00 | 24,677,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,959,868.73 | 39,098,255.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,999,898.00 | 16,999,233.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,529,674.00 | 164,015,780.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,410,774.00 | 7,779,980.00 |
| 210602 | Тавилга | - | 81,486,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,118,900.00 | 74,749,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 8,980,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 8,980,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 607,734,991.11 | 703,259,811.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 603,381,108.11 | 699,151,701.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 193,773.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 52,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 4,108,110.00 | 4,108,110.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 867,800,620.00 | 4,138,897,414.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 857,388,720.00 | 4,033,959,364.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,411,900.00 | 104,938,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,315,702,304.09** | **1,583,348,611.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,268,327,636.00 | 1,409,168,671.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 990,439,636.00 | 1,037,770,671.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 277,888,000.00 | 371,398,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 42,966,896.17 | 174,179,940.94 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,966,896.17 | 174,179,940.94 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,407,771.92 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,407,771.92 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **64,337,325.00** | **287,157,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **64,337,325.00** | **287,157,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **64,337,325.00** | **287,157,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 64,337,325.00 | 287,157,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 64,337,325.00 | 287,157,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(64,337,325.00)** | **(287,157,400.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 1,907,389,385.55 | 1,907,389,385.55 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | 1,907,389,385.55 | 1,907,389,385.55 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | 875,447,592.97 | 875,447,592.97 |
| 8 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 2,782,836,978.52 | 2,782,836,978.52 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | 2,782,836,978.52 | 2,782,836,978.52 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | - | 370,651,867.01 | 370,651,867.01 |
| 17 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 3,153,488,845.53 | 3,153,488,845.53 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Татаас санхүүжилтийн орлого** | **6,800,337,200.00** | **6,582,483,257.06** | **217,853,942.94** | **96.8** |
| **Улсын төсвөөс** | **6,800,337,200.00** | **6,582,263,259.06** | **218,073,940.94** | **96.8** |
| Урсгал | 6,800,337,200.00 | 6,582,263,259.06 | 218,073,940.94 | 96.8 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 219,998.00 | (219,998.00) | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,800,337,200.00** | **6,582,483,257.06** | **217,853,942.94** | **96.8** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,800,337,200.00** | **6,582,483,257.06** | **217,853,942.94** | **96.8** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,341,337,200.00** | **5,173,314,586.06** | **168,022,613.94** | **96.9** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,390,412,200.00 | 3,246,863,127.29 | 143,549,072.71 | 95.8 |
| Үндсэн цалин | 2,006,816,900.00 | 1,977,756,491.93 | 29,060,408.07 | 98.6 |
| Нэмэгдэл | 559,687,700.00 | 520,421,657.87 | 39,266,042.13 | 93.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 520,035,500.00 | 462,011,696.80 | 58,023,803.20 | 88.8 |
| Урамшуулал | 303,872,100.00 | 286,673,280.69 | 17,198,819.31 | 94.3 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **424,501,500.00** | **408,218,867.86** | **16,282,632.14** | **96.2** |
| Тэтгэврийн даатгал | 288,661,000.00 | 279,299,775.12 | 9,361,224.88 | 96.8 |
| Тэтгэмжийн даатгал | 33,960,100.00 | 32,805,328.85 | 1,154,771.15 | 96.6 |
| ҮОМШӨ-ний даатгал | 16,980,100.00 | 18,518,172.68 | (1,538,072.68) | 109.1 |
| Ажилгүйдлийн даатгал | 16,980,100.00 | 15,283,872.84 | 1,696,227.16 | 90.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 67,920,200.00 | 62,311,718.37 | 5,608,481.63 | 91.7 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **174,420,000.00** | **174,419,851.98** | **148.02** | **100.0** |
| Байрны түрээс | 174,420,000.00 | 174,419,851.98 | 148.02 | 100.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **81,677,000.00** | **80,774,488.93** | **902,511.07** | **98.9** |
| Бичиг хэрэг | 24,677,000.00 | 24,677,000.00 | - | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,000,000.00 | 39,098,255.93 | 901,744.07 | 97.7 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,000,000.00 | 16,999,233.00 | 767.00 | 100.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **415,261,100.00** | **414,198,180.00** | **1,062,920.00** | **99.7** |
| Багаж, техник, хэрэгсэл | 119,011,100.00 | 119,010,880.00 | 220.00 | 100.0 |
| Тавилга | 215,000,000.00 | 213,938,000.00 | 1,062,000.00 | 99.5 |
| Урсгал засвар | 81,250,000.00 | 81,249,300.00 | 700.00 | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | **9,000,000.00** | **8,980,000.00** | **20,000.00** | **99.8** |
| Дотоод албан томилолт | 9,000,000.00 | 8,980,000.00 | 20,000.00 | 99.8 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **654,739,500.00** | **652,524,811.00** | **2,214,689.00** | **99.7** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 650,201,800.00 | 648,416,701.00 | 1,785,099.00 | 99.7 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 190,600.00 | - | 190,600.00 | - |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 147,100.00 | - | 147,100.00 | - |
| Газрын төлбөр | 4,200,000.00 | 4,108,110.00 | 91,890.00 | 97.8 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **191,325,900.00** | **187,335,259.00** | **3,990,641.00** | **97.9** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 86,325,900.00 | 82,397,209.00 | 3,928,691.00 | 95.4 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 105,000,000.00 | 104,938,050.00 | 61,950.00 | 99.9 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,459,000,000.00** | **1,409,168,671.00** | **49,831,329.00** | **96.6** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **1,459,000,000.00** | **1,409,168,671.00** | **49,831,329.00** | **96.6** |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,039,000,000.00 | 1,037,770,671.00 | 1,229,329.00 | 99.9 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,000,000.00 | - | 45,000,000.00 | - |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 375,000,000.00 | 371,398,000.00 | 3,602,000.00 | 99.0 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **262** | **151** | **111** | **57.6** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.0** |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **130** | **75** | **55** | **57.7** |
| Удирдах ажилтан | 23 | 13 | 10 | 56.5 |
| Гүйцэтгэх ажилтан | 103 | 58 | 45 | 56.3 |
| Үйлчлэх ажилтан | 4 | 4 | - | 100.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **130** | **75** | **55** | **57.7** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 120 | 67 | 53 | 55.8 |
| Ажлын албаны албан хаагч (АА) | 4 | 3 | 1 | 75.0 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 4 | - | 100.0 |
| Улс төрийн албан хаагч (УТ) | 2 | 1 | 1 | 50.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **4,039,272,155.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,039,272,155.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 4,039,272,155.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 87,710,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 87,710,000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 3,951,562,155.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,951,562,155.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 4,039,272,155.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 4,039,272,155.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,951,562,155.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 87,710,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар нийт 287,964.4 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг 43,674.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. | 1 | 43,674.0 | 1 | 43,674.0 | - | - | 1 | 43,674.0 | - | - | - | - |
| Санхүү байдлын тайлангийн тавилга, аж ахуйн эд хогшлын хуримтлагдсан элэгдлийн дүнгээс үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн 1,552.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. | 1 | 1,552.7 | - | - | 1 | 1,552.7 | 1 | 1,552.7 | - | - | - | - |
| Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа хөтөлбөр, арга хэмжээгээр бүрэн тайлагнаагүй байна. | 1 | - | 1 | - | - | - | 1 | - | | - | - | - |
| Тусгай зориулалтын материал дансанд 31,774.4 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн дансанд 210,845.6 мянган төгрөг, аж ахуйн материал дансанд 117.8 мянган төгрөг нийт 242,737.7 мянган төгрөгийн гүйлгээг ерөнхий журналд гүйлгээний утгыг "Бэлэн бүтээгдэхүүн" гэсэн утгаар бүртгэсэн байна. | 1 | 242,737.7 | | | 1 | 242,737.7 | 1 | 242,737.7 | | | | |
| **Дүн** | **4** | **287,964.4** | **2** | **43,674.0** | **2** | **244,290.4** | **4** | **287,964.4** | | **-** | **-** | **-** |

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**3.2** Аудитаар нийт 26,080.9 мянган төгрөгийн 6 зөрчил[2] илэрснээс, сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага 1, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 22,899.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,181.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн захирагчийн мөнгөн гүйлгээний зарцуулалтыг нэгдсэн цахим системийн дүнтэй тулган шалгахад 78,024,266.3 мянган төгрөгөөр дутуу гүйлгээтэй холбоотой Төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайланд хөтөлбөр, арга хэмжээ, соёлын салбарын хөрөнгө оруулалт зэрэг дансаар хийгдсэн ажил гүйлгээг иж бүрэн тайлагнаж ирүүлээгүй. | 1 | | - | - | | | 1 | | | | | |
| Төсөв захирагчийн техник хяналт, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. | 1 | | | | | | | | 1 | 1 | | |
| Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 517.3 мянган төгрөгийн авлага, 2,444.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. | 1 | 2,961.5 | - | - | - | | 1 | 2,961.5 | - | - | - | - |
| Жил бүр давтагддаг соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг нөхөн авах хураамжийн өөрийн орлогыг төлөвлөөгүй байна. | 1 | 220.0 | - | - | - | | 1 | 220.0 | - | - | - | - |
| Ахмадын санг зохих журмын дагуу байгуулаагүй боловч уг сангийн зориулалтыг үндэслэн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 13,900.0 мянган төгрөгийн зардлыг гаргасан байна. | 1 | 13,900.0 | - | - | 1 | 13,900.0 | - | - | - | - | - | - |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж 8,999.4 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авч зарцуулсан. | 1 | 8,999.4 | | | 1 | 8,999.4 | | | | | | |
| **Дүн** | **6** | **26,080.9** | **-** | **-** | **2** | **22,899.4** | **3** | **3,181.5** | **1** | **1** | | **-** |

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 5 зөрчилд 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлуулаагүй, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор байршуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Төсвийн захирагч нь цахим дэлгүүрт тайлант оны худалдан авалтын захиалга, хүсэлтийг хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 339,412.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Шилэн дансны мэдээллийн санд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 1,744,084.3 мянган төгрөгийн 10, зарлагын 1,714,125.9 мянган төгрөгийн 47 гүйлгээ мэдээлээгүй | 1 | - | - | - | 1 | | - | - | - | - | - | - |
| Хөдөлмөрийн аюулгүй байдлын хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдалд төсвийн хөрөнгийн 0.5 хувиас доошгүй хөрөнгийг төлөвлөж ажиллаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Монгол Улсыг олон улсад сурталчлах үндэсний хороонд 3 иргэнтэй 2-3 сая төгрөгийн, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороонд 5 иргэнтэй 3-3.5 сая төгрөгийн нийт 8 иргэнтэй 144.0 сая төгрөгийн хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан байна. Гэрээний ажлын даалгаврыг "өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх"-ээр байгуулсан нь тус хорооны өөрсдийн хийх үндсэн ажилтай зарим чиг үүргийн ажил давхардаж байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **5** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **4** | **-** | **-** | **-** | **-** | **-** |